



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 08 сарын 22 өдөр

Дугаар А/50

Чойр

GS5 эрхийг шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Сангийн сайдын 2014 оны 95 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх журам”-ын 5.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх журам”-ын 3.13.“20” дахь хэсэгт заасан GS5 эрхийг 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн Санхүү, төрийн сангийн хэлтсийн Бүртгэл, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн (Б.Гүнжидмаад)-д шилжүүлсүгэй.

2.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн Б/24 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Отгонтуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.СОДНОМ

4222200397